

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### АЖЛЫН ДААЛГАВАР

#### ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн даргын "Хяналт үнэлгээний баг томилох тухай" 2022 оны А/09 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт "Хяналтын үнэлгээний багийн ажлын удирдамж"-д заагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын сургалтын орчин, багшлах бүрэлдэхүүн, тээврийн хэрэгслийн шаардлага, шалгуур үзүүлэлт.

№	Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, тээврийн хэрэгсэл	Шалгуур үзүүлэлт
<b>Нэг. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын сургалтын орчин, хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага</b>		
1	Зориулалтын барилга, байгууламжид тавигдах шаардлага	Өөрийн өмчийн болон түрээсийн байр Улсын бүртгэлийн гэрчилгээ эсвэл түрээсийн гэрээгээр баталгаажуулсан байх
		Суудлын тоо, багтаамж, онолын танхимын талбайн хэмжээ MNS:6541 стандартад заасан шаардлага хангасан байх /Нэг ээлжид дүрмийн хичээлд суух барилга байгууламжид сонсогчийн тоо, суудлын тоотой нийцтэй эсэх, нэг суралцагчид ногдох хэмжээ 2 м <sup>2</sup> -аас багагүй, хичээлийн хуваарьтай харьцуулах/
		Ариун цэврийн өрөө, бие засах газартай, суралцагч ашиглах боломжтой байх
		Суралцагч болон багшид зориулсан ширээ, сандал самбар стандарт шаардлага хангасан байх
2	Сургалтын танхимд тавигдах шаардлага	Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, агааржуулалт, эрүүл ахуйн холбогдох стандартын шаардлага хангасан байх
		Дулаацуулах системтэй шаардлага хангасан байх
		Галын аюулгүй байдлын мэдээлэл, галын хорыг шаардлагын дагуу байрлуулсан, галын дүгнэлт гаргуулсан байх;
		Онолын сургалтыг цахим хэлбэрээр явуулах зориулалтын программ хангамж тоног төхөөрөмжтэй, интернэт сүлжээнд холбогдсон, нэг ээлжид орох суралцагч нарт хүртээмжтэй байх;

3	Жолоодлогын дадлагын талбайд тавигдах шаардлага	Жолоодлогын дадлагын талбайн хэмжээ 4000 м/кв-аас дээш нийтийн эзэмшлийн зам талбай, замын хөдөлгөөнөөс бүрэн тусгаарласан хаалт хашаатай байх
		Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан хэсэг нь хатуу эсвэл сайжруулсан хучилттай тэгш гадаргуутай байх
		Бүрэнхий үед жолоодлогын дадлагыг хэвийн явуулах нөхцөлийг хангахуйц гэрэлтүүлэгтэй, гэрэлтүүлэг нь нийт талбайд жигд тархсан байх
		Тухайн ангиллын тээврийн хэрэгслээр жолоодлогын дадлага хийх сургалтын хөтөлбөрийн дагуу жолоодлогын үйлдлийн элементүүдээр тоногдсон байх
		Хяналтын шонгийн өндөр нь 1200 мм-ээс 1400 мм, голч нь 15 мм-ээс 20 мм, улаан, цагаан, шар өнгөөр ээлжлүүлэн 200 мм-ийн судал гаргаж тойруулан будсан байх
		Анхны тусламжийн болон галын аюулаас хамгаалах хэрэгсэлтэй байх
		Бие засах газар, хог хаягдлын цэгтэй байх
		Өөрийн өмчийн гэрчилгээ болон түрээсийн гэрээгээр баталгаажуулсан байх
		"B" ангиллын дадлага хийх боломжийг бүрдүүлсэн байх
4	Сургалтын материал, хэрэглэгдэхүүн	Сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөлт хийж, захирагчаар баталгаажуулсан байх
		Хичээлийн хуваарийг өглөө, өдөр, оройн ээлжээр, дүрмийн болон дромын, хотын жолооны, цахим, танхимын олон хувилбараар боловсруулж баталгаажуулан нүдэнд харагдах газарт байрлуулсан байх
		Сургалтын хөтөлбөрт нийцсэн шаардлага хангасан зурагт хуудаснуудыг нүдэнд харагдах газарт байршуулсан байх
		Суралцах бүхий л хэлбэрт тохиосон агуулга, тест, гарын авлага, тараах материалыг шаардлагын дагуу бэлтгэсэн байх /ном, гарын авлага, тараах материал гэх мэт/
		Суралцагчийн дадлагын дэвтэртэй байх
		Суралцагчтай хийх гэрээний загварыг боловсруулсан байх
		Суралцагчийг бүртгэх анкет, эрүүл мэндийн хуудсыг бэлтгэсэн байх
		Цахим хичээл, хэрэгдэхүүний сан, явцын үнэлгээ хийх тестийн цахим санг бэлдсэн байх
Хоёр. Жолооны багшлах бүрэлдэхүүн		
5	Дүрмийн болон жолоодлогын багш	Дүрмийн болон жолоодлогын багш нь эрх бүхий байгууллагаас олгосон багшлах эрхийн /хүчинтэй/ үнэмлэхтэй байна. /Багш өөрийн биеэр, үнэмлэх нь эх хувиараа байх/

		<p>Жолоодлогын багш нь техникийн буюу түүнээс дээш боловсролтой, тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, уг ангиллын тээврийн хэрэгслийн 5-аас дээш жил тасалдалгүй жолоодсон байх</p> <p>Дүрмийн багш нар нь авто механик инженер мэргэжилтэй, бакалавраас дээш боловсролтой байх /лавлагаа/</p> <p>Багш нар нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчиж, жолоодох эрхээ хасуулаагүй байх /лавлагаа/</p>
<b>Гурав. Жолооны сургалтын тээврийн хэрэгсэл</b>		
6	Тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага	Өөрийн өмчийн тээврийн хэрэгсэлтэй байх /Захирал болон байгууллагын нэр дээр байгааг улсын дугаараар нь шалгах/
		Тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байх /хяналтын үзлэгийн баримт/
		Замын хөдөлгөөний дүрэмд заасан ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэл техникийн зөрчилгүй байх /Бодит байдал дээр машиныг үзэх/
		Бүртгэлийн санд бүртгэлтэй байх
		“Сургалтын тээврийн хэрэгсэл” таних, тэмдэг, улаан хүрээ бүхий адил талт гурвалжин дотор “С” үсгийг хар өнгөөр бичсэн байх Мотоцикл, механизмаас бусад тээврийн хэрэгсэл зүүн гар талдаа жолооны хүрдтэй байх
7	Тээврийн хэрэгсэлд тавих тусгай шаардлага	Багшид зориулсан тоормосны нэмэлт дөрөө MNS4599 шаардлага хангасан байх
		Ар талыг харах нэмэлт тольтой багшийн суудлаас үзэх боломжийг хангасан, тухайн тээврийн хэрэгслийн үйлдвэрээс тавьсан толиноос ихгүй хэмжээтэй байх
		Жолоочийн болон багшийн суудлын тохируулга саадгүй ажилладаг байх
		Тээврийн хэрэгслийн өнгө гэрчилгээнд заасан өнгөнөөс зөрүүгүй байх /хаалга, их бие, бусад хэсгийн өнгө/
8	Техникийн бүрэн бүтэн байдал №1	Салхины шилнүүд бүрэн бүтэн, цонхнууд саадгүй онгойж хаагддаг байх
		Хаалга саадгүй онгойж хаагддаг байх /гадна, дотроосоо/
		Хянах хэмжих хэрэгслүүд бүрэн ажиллагаатай байх
9	Техникийн бүрэн бүтэн байдал №2	Дуут дохио шаардлага хангасан байх
		Гар тоормос шаардлага хангасан байх
		Хамгаалах бүс бүрэн, ажиллагаатай байх
		Гэрэлтүүлэх хэрэгслүүд бүрэн ажиллагаатай байх
10	Анхны тусламж болон галын аюулаас	Бүхээгийн дотор тал эрүүл ахуйн шаардлага хангасан байх
		Автомашинд зайлшгүй байх хэрэгслүүд бүрэн